


Боловсрол, соёл, шинжлэх ухааны
сайдын 2016 оны 02 дугаар сарын 19-ны
өдрийн А/50 дугаар тушаалын хавсралт



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр Дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ) болон үйлдвэрлэлийн түншлэл хөгжүүлэх төсөлд тэтгэлэг /цаашид “тэтгэлэг” гэх/ олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёоллыг дор дурьдсан утгаар ойлгоно:

1.2.1. “Дээд боловсролын сургалтын байгууллага” гэж боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасныг;

1.2.2. “Гарааны компани” гэж Инновацийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасныг;

1.2.3. “Энтрепренершип” гэж шинэ санааг бизнес болгон ашиг олоход чиглэгдсэн үйл ажиллагааг хэлнэ.

1.3. Дараах зорилгоор хэрэгжүүлэх төсөлд тэтгэлэг олгоно:

1.3.1. ДБСБ ба үйлдвэрлэлийн түншлэлийг харилцан үр ашигтай хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх,

1.3.2. Үйлдвэр эсвэл гарааны компаний туршилт, судалгааны ажилд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх технологийн шинэ, шинэлэг шийдэл дэвшүүлж хэрэгжүүлэх,

1.3.3. Оюутнуудад үйлдвэрлэлийн орчинд практик сургалтыг шинэ хэлбэрээр үр дүнтэй явуулах,

1.3.4. Энтрепренершипыг хөгжүүлэх

1.4. Төсөл сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх, тэтгэлэг олгоход дараах үндсэн зарчмыг баримтална:

1.4.1. Байгалийн ухаан, Инженер технологи, Хөдөө аж ахуй гэсэн тэргүүлэх чиглэлд хамаарсан байх;

1.4.2. Үр ашигтай байх,

1.4.3. Өрсөлдөх тэгш боломжтой байх,

1.4.4. Ил тод, нээлттэй байх,

1.4.5. Хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байх.

1.5. Тэтгэлгийг энэхүү журмын 1.3-т заасан зорилгыг хэрэгжүүлж, өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад шалгарсан төслийн багт олгоно. Төслийн баг нь 6-14 хүний бүрэлдэхүүнтэй байна. Төслийн багт дээд боловсролын сургалтын байгууллагын багш, оюутан, холбогдох аж ахуйн нэгж, үйлдвэр эсвэл гарааны компанийн төлөөлөл байна. Төслийн үр дүнг сайжруулах үүднээс өөр мэргэжлээр суралцагч оюутныг хамруулж болно. Төслийн багийн гишүүн нь энэхүү журмаар зарлагдаж буй нэгээс илүү тооны төсөлд удирдагч эсвэл гүйцэтгэгчээр ажиллахгүй байхыг зөвлөж байна. Багийн бүрэлдэхүүний 40-өөс багагүй хувь нь эмэгтэй байна.

1.6. Төслийн багийн удирдагч (цаашид “Төслийн удирдагч” гэх) нь магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага ба түүний харьяа эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн ажилтан байх бөгөөд докторын зэрэгтэй, эшлэлийн системд ордог эрдэм шинжилгээний мэдээллийн сан бүхий олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн байна.

1.7. Тэтгэлгийн хэмжээ 50.0 /тавь/ сая төгрөг хүртэл байна.

1.8. Төсөл хэрэгжүүлэх хугацаа 9 сар хүртэл байна.

1.9. Төслийг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- 1.9.1. сонгон шалгаруулах,
- 1.9.2. гэрээ байгуулж санхүүжүүлэх,
- 1.9.3. төсөл хэрэгжүүлэх,
- 1.9.4. үр дүнг тайлагнах,
- 1.9.5. үр дүнг хүлээлгэн өгөх.

Хоёр. Төсөл сонгон шалгаруулах

2.1. Дээд боловсролын шинэчлэлийн төсөл хэрэгжүүлэх нэгжээс /цаашид “ТХН” гэх/ төсөл сонгон шалгаруулах зарыг өдөр тутмын сонин, яамны цахим хуудас зэрэг мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлана. Зар гарсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор төслийн баримт бичгийг БСШУЯ-нд ирүүлнэ.

2.2. Төсөл сонгон шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулна. Эхний үе шатанд төслүүдийг харьяалах сургуулийнх нь Эрдмийн зөвлөл хэлэлцэж 2 хүртэлх тооны төсөл сонгон шалгаруулна. Сүүлийн шалгаруулалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам зохион байгуулна.

2.3. Уралдаанд оролцохыг хүсэгч нь уралдаанд орох хүсэлтээ сургуулийн удирдлагад илэрхийлэх бөгөөд баг бүрдүүлж, төслийн баримт бичгийг зааврын дагуу бэлтгэж боловсруулна. Өргөдлийн маягт болон зааврыг Дээд боловсролын шинэчлэл төслийн вэб хуудаснаас (www.nerp.mn) татаж авна. Төслийн баг нь боловсруулсан төслөө харьяалах сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, шалгарсан тохиолдолд

төслийн баримт бичгийг Эрдмийн зөвлөлийн протокол болон сургуулийн удирдлагаас дэмжсэн тухай албан бичгийн хамт Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Инновац, өндөр технологийн газарт төсөл хүлээн авах эцсийн хугацаанд багтаан ирүүлнэ.

2.4. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь ирүүлсэн төсөл бүрээр 3 шинжээч ажиллуулж үнэлгээ хийлгэнэ. Шинжээчийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн А/83 тоот тушаалаар батлагдсан шинжлэх ухааны холбогдох чиглэлийн шинжээчдээс сонгох бөгөөд шинжээч нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/77 тоот тушаалаар батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах аргачлал”-ыг мөрдөн бие даасан үнэлгээ хийнэ. Шинжээчдийн гаргасан бие даасан үнэлгээнд үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилсон Олон талт төлөөлөл бүхий хорооны хурлаар хэлэлцэж сонгон шалгаруулна. Олон талт төлөөлөл бүхий хорооны хуралдааны шийдвэрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.5. Шалгарсан төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон ТХН-ийн вэб хуудсанд байршуулах ба ажлын 5 хоногт багтаан төслийн удирдагч болон харьяалах сургуульд нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас албан бичгээр мэдэгдэнэ.

Гурав. Төслийн гэрээ байгуулж санхүүжүүлэх

3.1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь харьяалах сургуулийн удирдлага болон шалгарсан төслийн багтай төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулна.

3.2. Тэтгэлгийг дараах байдлаар олгоно. Үүнд:

3.2.1. Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зардалд зориулж нийт тэтгэлгийн 70 хувийг төслийн эхэнд олгоно;

3.2.2. Төсөл амжилттай хэрэгжиж дуусахад энэхүү журмын 6.2-т үндэслэж үлдэгдэл 30 хүртэлх хувийг олгоно.

Дөрөв. Төсөл хэрэгжүүлэх үе шат

4.1. Төслийн удирдагчийн удирдлаган дор багийн гишүүд төлөвлөсөн хугацаандаа үр бүтээлтэй ажиллана. Төслийн удирдагч, аж ахуйн нэгж, үйлдвэр эсвэл гарааны компанийн төлөөлөл нь багийн гишүүдийн жигд оролцоог хангана. ТХН-ээс төслийн багт холбогдох зөвлөгөө өгч дэмжиж ажиллана.

4.2. Төслийн багаас хэрэгжилтийн явц, ахицын болон санхүүжилтийн зарцуулалтын тайланг сар тутам бичнэ. Тайланг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам ба ТХН-ээс өгөх чиглэл, зөвлөмжийн дагуу бэлтгэнэ.

4.3. Төслийн хэрэгжилтийн явцад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны холбогдох газар хэлтэс болон ТХН-ийн зүгээс хамтран мониторинг хийнэ.

4.4. Төслийн удирдагч нь багийг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, төсөлд зориулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, үр дүнг захиалагчийн өмнө хариуцах үүрэг хүлээнэ.

Тав. Төслийн үр дүнг тайлагнах

5.1. Төсөл дуусахад төслийн баг нь 1.3-т заасан зорилгыг хэрэгжүүлсэн үр дүн болон санхүүжилтийн зарцуулалтын талаар англи, монгол хэл дээр тайлан бичиж сургуулийнхаа эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

5.2. Төслийн баг нь тайлангаа Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд дараах баримтын хамт хүргэнэ:

5.2.1. Сургуулийнхаа эрдмийн зөвлөлөөр тайлангаа хэлэлцүүлсэн протокол;

5.2.2. Төслийн явцад гарсан эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл зэрэг бусад бүтээл.

5.3. 2017 оны 1 дүгээр сард багтаж Олон талт төлөөлөл бүхий хороог хуралдуулж тэтгэлэгт төслүүдийн тайлан, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргана. Амжилттай хэрэгжсэн төслүүдийг нийтэд түгээн дэлгэрүүлэх асуудлаар шийдвэр гаргана.

5.4. Хэрэв төслийн багийн буруугаас төслийн үр дүн хангалтгүй гарсан бол тухайн төслийн талаар харьяалах сургуульд нь мэдэгдэж, үлдэгдэл тэтгэлгийг олгохгүй бөгөөд төслийн удирдагч ба харьяалах сургуулийн удирдлагад гэрээнд заасны дагуу хариуцлага тооцно.

Зургаа. Төслийн үр дүнг хүлээлгэн өгөх

6.1. Төсөл бүрэн хэрэгжиж дууссаны дараа Төслийн баг нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж, хүлээн авах акт”-ыг 3 хувь үйлдэж харьяа сургууль, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Инновац, өндөр технологийн газар болон ТХН-д тус бүр нэг хувийг хүргүүлнэ.

6.2. ТХН-ээс энэхүү журмын 6.1-д заасан актыг хүлээн авснаас хойш 20 хоногт багтаан төслийн багтай санхүүжилтийн тооцоог хийж дуусгавар болгоно.

6.3. Төсөл хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, хүлээлгэн өгөхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх тухай гэрээнд тодорхой тусгана.

Долоо. Бусад

7.1 ДБСБ нь төслийн үр дүнг үйл ажиллагаандаа бүрэн эсвэл үе шаттайгаар нэвтрүүлсэн, цаашид хөгжүүлсэн тухай тайланг Олон талт төлөөлөл бүхий хорооноос 2017 оны 1 дүгээр сард өгөх чиглэл, зөвлөмжийн дагуу бичиж, төсөл дууссанаас хойш 1 жилийн дараа Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Инновац, өндөр технологийн газар ба ТХН-д ирүүлнэ.

---o0o---